



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨРИЙН  
ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс, (976-51) 26 74 68. Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024. 10.25 № 03/8852  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тендер шалгаруулалтыг  
түдгэлзүүлэх тухай

Танай байгууллагаас зарласан ЭҮТӨҮГ/202401011409 дугаартай “Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн хичээлийн 2 дугаар байрны их засвар” ажлын гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон “Сант-Өндөр” ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам” (цаашид “журам” гэх)-ын 4.1-д заасны дагуу гомдол гаргасан байна.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.6 дахь хэсгийг үндэслэн захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлж байна.

Иймд гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай дараах баримт бичгийг 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Үүнд:

1. Батлагдсан төсөвт өртгийн шийдвэрийн хуулбар;
2. Үнэлгээний хороо байгуулсан шийдвэр;
3. Батлагдсан тендер шалгаруулалтын баримт бичиг;
4. Оролцогчдын ирүүлсэн тендер /Тендер нээх нууц үг/;
5. Тендерийн нээлтийн тэмдэглэл;
6. Үнэлгээний хорооны зөвлөмж, хурлын тэмдэглэл;
7. Оролцогч болон бусад байгууллагуудтай харилцсан бичиг;
8. Гэрээ байгуулах эрх олгох, шалгараагүй болон татгалзсан тухай шийдвэр;
9. Захиалагч гомдол хянан шийдвэрлэсэн бол холбогдох шийдвэр;
10. Холбогдох бусад баримт бичиг.

Түүнчлэн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.9 дэх хэсэгт заасны дагуу бусад оролцогч нарт энэхүү шийдвэрийг мэдэгдэх, журмын 5.2-т заасны дагуу гомдол гаргагчийн тендерийн баталгааг чөлөөлөхгүй байхыг үүгээр мэдэгдэж байна.

Гомдлыг хянан шийдвэрлэх хугацаанд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасан хугацаа зогсох болно.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Ж.ГАНБАТ

9766016587



## “ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”

ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027

Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,

Цахим шуудан: info@erdenetmc.mn,

Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024.10.30 № АБ-124-12/ 6885  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Материал хүргүүлэх тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан ЭҮТӨҮГ/2024010111409 дугаартай “Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн хичээлийн 2 дугаар байрны их засварын ажил”-ын тендерт оролцсон “Сант Өндөр” ХХК нь гомдол гаргасны дагуу хянан шийдвэрлэхэд шаардлагатай дараах баримт бичгүүдийг хүргүүлж байгааг хүлээн авна уу. Үүнд:

- Батлагдсан төсөвт өртгийн шийдвэрийн хуулбар,
- Захиалагчийн үнэлгээний хороо томилсон тушаал,
- Захиалагчийн баталсан тендерийн баримт бичиг,
- Оролцогчдын ирүүлсэн тендер,
- Тендерийн нээлтийн тэмдэглэл,
- Үнэлгээний хорооны зөвлөмж, хурлын тэмдэглэл,
- Шалгараагүй болон татгалзсан тухай шийдвэр.

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Т.БАТМӨНХ

ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН ГИШҮҮН

612407035425



БҮРХУУД ХХК-Д

**“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”**

**ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР**

Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027

Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,

Цахим шуудан: info@erdenetmc.mn,

Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024. 10. 30 № 115-134-12/6826

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

Гэрээ байгуулах эрх олгосон мэдэгдлийг  
түр хугацаагаар түдгэлзүүлсэн тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан ЭҮТӨҮГ/2024010111409 дугаартай “Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн хичээлийн 2 дугаар байрны их засварын ажил” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцсон “Сант Өндөр” ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1-д заасны дагуу гомдол гаргасан тул Сангийн яамны 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 03/8852 дугаартай албан бичгээр гүйцэтгэгч сонгох ажиллагааг түр хугацаагаар түдгэлзүүлсэн болохыг мэдэгдье.

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Т.БАТМӨНХ

ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН ГИШҮҮН

612407035424



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

**“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”**

**ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР**

Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027

Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,

Цахим шуудан: info@erdenetmc.mn,

Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024.10.30 № 75-134-12/6884  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Захиалагчийн шийдвэр гаргах хугацааг  
сунгах тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан ЭҮТӨҮГ/2024010111409 дугаартай “Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн хичээлийн 2 дугаар байрны их засварын ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцсон “Сант Өндөр” ХХК нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 59 дүгэр зүйлийн 59.6 дахь хэсэг, Сангийн яамны 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам” (цаашид “журам” гэх)-ын 4.1-т заасны дагуу гомдол гаргасан.

Тус гомдлын дагуу Сангийн яам 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 03/8852 дугаартай албан бичгээр хуулийн 59.10-т заасан шийдвэр гаргасан тул хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийг үндэслэн захиалагчийн шийдвэр гаргах хугацааг ажлын 15 хоногоор сунгаж байгааг мэдэгдье.

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Т.БАТМӨНХ

ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН ГИШҮҮН

612407035428